



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 11495

Арвайхээр

Үндэсний сурын харвааны цол олгох тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 9 дүгээр зүйлийн 9.3, 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Их Монгол Улс байгуулагдсаны 813, Ардын хувьсгалын 98, аймаг байгуулагдсаны 88 жилийн ой, аймгийн баяр наадмын Үндэсний сурын харвааны эрэгтэй төрөлд түрүүлсэн Өвөрхангай аймгийн Хархорин сумын харьяат “Цээл Бүзэнхий” ХХК-ний харваач, Монгол улсын спортын мастер Баатардоржийн Зундуй, Үндэсний сурын харвааны эмэгтэй төрөлд түрүүлсэн Өвөрхангай аймгийн Төгрөг сумын харьяат, Арвайхээр сумын “Мэргэд” лабортори сургуулийн харваач Содномдоржийн Лхагвасүрэн нарт “АЙМГИЙН МЭРГЭН” цол олгосугай.

2. Үндэсний сурын харвааны эрэгтэй төрөлд хоёрдугаар байр эзэлсэн Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын харьяат “Тод прогресс” ХХК-ний харваач Монгол улсын спортын мастер Бат-Ёндөнгийн Намбардуламд аймгийн “ГАРАМГАЙ ХАРВААЧ” цол олгосугай.

3. Их Монгол Улс байгуулагдсаны 813, Ардын хувьсгалын 98, аймаг байгуулагдсаны 88 жилийн ой, аймгийн баяр наадмын Үндэсний сурын харвааны өсвөр насны эрэгтэй төрөлд түрүүлсэн Өвөрхангай аймгийн Богд сумын харьяат, “Есүн тайж” клубын харваач Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 9в ангийн сурагч Баатарын Даваадорж, өсвөр насны эмэгтэй төрөлд түрүүлсэн Өвөрхангай аймгийн Уянга сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн ба ангийн сурагч Ариунболдын Цолモン-Эрдэнэ нарт “ИДЭР МЭРГЭН” цол тус тус олгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100860

D:My Doc. Zahiramj. Zasag darga